



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/323

Булган сум

Зөвлөн туслах ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутаг дахь төрийн албаны хуулийн хэрэгжилт, өвөлжилт хаваржилтын нөхцөл байдал, салбаруудын ажлын явц хийж хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцах зорилгоор Могод, Бүрэгхангай сумдад ажиллах 25 хүний бүрэлдэхүүнтэй алба хаагчдын байр, хоолны зардалд 4,200,000 (дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
А/323 дугаар захирамжийн хавсралт

Зөвлөн туслах ажилд шаардагдах төсөв

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Буудал	25 хүн	ш	120,000	3,000,000
2	Оройн хоол	25 хүн	ш	28,000	700,000
3	Өглөөний хоол	25 хүн	ш	20,000	500,000
Нийт дүн					4,200,000

--o00o--